



АЙМГИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
Х.Бекен
Утас: 70422954
Цахимхаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахимхаяг:

Аудитор: Б.Үүрийнтуяа
Утас: 89838414
Цахимхаяг:

Хаяг: Баян-Өлгий аймгийн
Аудитын газар
Байршил: Аймгийн ЗДТГ-ын
байр, 1-р давхар
Цахим хуудас: www.audit.mn

2015 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас Халамжийн сангийн орон нутгийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд БӨА-2018/8/СТА-ОНТС аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Халамжийн сангийн орон нутгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Халамжийн сангийн орон нутгийн төсвийн 2017 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 20-ноос 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн хийж хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас Халамжийн сангийн орон нутгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 25-нд Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 20 -ноос 2018 оны 2 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 28-нд Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн халамжийн тухай багц хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн

үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 1-р зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зарцуулах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Бусад төсвийн байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Халамжийн сангийн орон нутгийн 2017 оны төсвийг Аймгийн ТЭЗ-ийн орон нутгийн төсвөөс аймаг, сумын Төрийн сангаар дамжуулан олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Халамжийн сангийн орон нутгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, Жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд олгох мөнгөн тэтгэмж, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, Хүнс тэжээлийн хөтөлбөр, Халамжийн сан үндсэн 4 томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 12-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад **санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж мөрдөн ажиллаагүй** боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Халамжийн сангийн орон нутгийн төсвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Халамжийн сангийн орон нутгийн төсвийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Халамжийн сангийн орон нутгийн төсвийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Халамжийн сангийн 2017 оны орон нутгийн төсвийг аймгийн Засаг даргаас сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Халамжийн сангийн орон нутгийн үйл ажиллагаанд тайлант онд 11108,3 сая төгрөгийн төсөв батлагджээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 10612,1 сая төгрөгийн санхүүжилт авч, хүүгийн орлогоос 2,2 сая төгрөгийн орлого оруулж нийтдээ 10614,3 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, оны эцэст 6,3 сая төгрөгийг төөвт татан төвлөрүүлсэн байна.

Сангуудын төсвийн гүйцэтгэлийг төрлөөр нь авч үзвэл: Жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд олгох мөнгөн тэтгэмжинд 1461,5 сая төгрөгийн, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 52,6 сая төгрөгийн, Хүнс тэжээлийн хөтөлбөрт 822,9 сая төгрөгийн, Халамжийн сангийн санхүүжилтэнд 8270,1 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгджээ.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит V хуралдааны 12 дугаар тогтоолоор орон нутгийн 2017 оны төсвийг батлахдаа Сангийн яамнаас хянаж ирүүлсэн Халамжийн сангийн /орон нутаг/ 2017 оны төсвийг 496,1 сая төгрөгөөр бууруулж 9771,3 сая төгрөгөөр баталж, орон нутгийн төсөвт байгууллагуудын урсгал зардалд шилжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит III хуралдааны 25 дугаар тогтоолоор орон нутгийн 2017 оны тодотгосон төсвийг батлахдаа Сангийн яамнаас хянаж ирүүлсэн Халамжийн сангийн /орон нутаг/ 2017 оны тодотгосон төсвийг мөн 496,1 сая төгрөгөөр бууруулж 10612,1 сая төгрөгөөр баталсан байна.

2016 оны эцэст Халамжийн сангийн дансны үлдэгдэл 146,7 сая төгрөг, санхүүжилтийн олгогдоогүй үлдэгдэл 590,6 сая төгрөг бүгд 737,3 сая төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансанд татан төвлөрүүлсэн байна. Энэхүү татан төвлөрүүлсэн Халамжийн сангийн хөрөнгийг 2017 онд санд нь буцаан олгоогүй байна.

Халамжийн сан нь 2016 оны эцэст 597,9 сая төгрөгийн өглөгтэй гарч санхүүгийн тайланд тусгагдаж, үүнээс 2017 онд 288,6 сая төгрөгийг барагдуулж, 309,3 сая төгрөгийн өглөг барагдаагүй байна.

Халамжийн сан нь 2017 онд шинээр 639,3 сая төгрөгийг өглөг үүсгэж оны эцэст нийтдээ 948,3 сая төгрөгийн өглөгтэй гарч оны эхнээс 350,4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дээрхи байдлаас дүгнэлт хийж үзэхэд Халамжийн сангийн дансны үлдэгдэл, санхүүжилтээс 2016 оны эцэст орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн хөрөнгийг буцаан олгох арга хэмжээ аваагүй, Халамжийн сангийн 2017 оны төсвийг үндэслэлгүй бууруулж баталсны улмаас он дамжсан өртэй гарахад хүргэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нийгмийн халамжийн тухай хуулийн 8.1-д “Тэтгэвэр, тэтгэмжийн сангийн хөрөнгийг зөвхөн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид зарцуулна”, 8.2-т “Нийгмийн үйлчилгээний сангийн хөрөнгийг дараах үйлчилгээг санхүүжүүлэхэд зарцуулна”, 8.3-т “Халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор Нийгмийн даатгалын сангийн болон төсвийн 2017 оны батлагдсан төсвийг ХХҮЕГазрын нэгдсэн цахим хуудсанд байршуулсан байна.

Халамжийн сангийн улсын төсвийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, 5,0 сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй гүйлгээг цахим хаягт байршуулах талаар тусгаж, төсвийн талаарх мэдээллийг байгууллагын самбар байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 12 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Санхүүгийн тайлангийн явцад гарсан алдаа зөрчлүүд нь байгууллагын тайланд материаллаг хэмжээний нөлөө үзүүлээгүй.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Халамжийн сангийн орон нутгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний Жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд олгох мөнгөн тэтгэмжийн санхүүжилт, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, Хүнс тэжээлийн хөтөлбөр, Халамжийн сангийн орлого, зарлага, төвлөрүүлэх шилжүүлэг зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Халамжийн сангийн орон нутгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад аудитын цаг хугацааны шахуу байдлаас үүдэн Халамжийн сангийн орон нутгийн төсвөөс олгогдсон халамж үйлчилгээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн үр дүнг гүйцээж даган мөшгин шалгах боломжгүй бөгөөд эрсдэлтэй асуудал гарч магадгүй учраас гүйцэтгэлийн шалгалтаар бүрэн хамруулж шалгаж дүгнэлт гаргах нь зүйтэй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Халамжийн сангийн орон нутгийн төсвийн тайланд алдаа, зөрчил илрээгүй.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд зөвлөмж өгөгдөөгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн Халамжийн сангийн орон нутгийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА
2018.02.28

